



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 02 сарын 11 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

Төрийн өмчид эд хөрөнгө бүртгэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны 148 дугаар тогтоолын 4 дэх заалт, Баянхонгор аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн 26 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Баянхонгор аймгийн өмчөөс шилжүүлсэн нийт 1 нэрийн 170,635,142.00 (нэг зуун далан сая зургаан зуун гучин таван мянга нэг зуун дөчин хоёр) төгрөгийн балансын үнэ, 6,635,811.00 (зургаан сая зургаан зуун гучин таван мянга найман зуун арван нэг) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг төрийн өмчид хүлээн авч, Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын үндсэн хөрөнгөд бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2. Онцгой байдлын ерөнхий газрын дарга, хошууч генерал Т.Бадрал, Баянхонгор аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга Ц.Идэрмөнх нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Шилжүүлж буй үл хөдлөх хөрөнгөд хамаарах газар эзэмших эрхийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу Баянхонгор аймгийн Онцгой байдлын газрын нэр дээр баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэлийн хэлтэст үүрэг болгосугай.

ДАРГА


З.МЭНДСАЙХАН

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

0000046

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2020 оны 02 дүгээр сарын 11-ны өдрийн
 30 дугаар тогтоолын хавсралт



**БАЯНХОНГОР АЙМГИЙН ӨМЧӨӨС ТӨРИЙН ӨМЧИД ХҮЛЭЭН АВЧ
 БАЯНХОНГОР АЙМГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглалта д орсон он	Хэм- жих нэгж	Тоо хэм- жээ	Балансын үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
1	Баянхонгор аймгийн Баянцагаан сум дахь Өвсний фондын барилга	2016	ш	1	170,635,142.00	6,635,811.00	163,999,331.00
	Нийт дүн				170,635,142.00	6,635,811.00	163,999,331.00
					(нэг зуун далан сая зургаан зуун гучин таван мянга нэг зуун дөчин хоёр)	(зургаан сая зургаан зуун гучин таван мянга найман зуун арван нэгэн)	(нэг зуун жаран гурван сая есөн зуун ерэн есөн мянга гурван зуун гучин нэгэн)